

Алсын зайнаас буюу онлайнаар суралцахад хүүхдэдээ хэрхэн туслах вэ?

- **Сургуулиас өгсөн гэрийн даалгаврыг танай хүүхэд хэрхэн ойлгож хүлээн авч байгааг шалга** Хуваарыт хичээл анги танхимд хичээллэхгүй байгаа боловч онлайн хэлбэрээр хичээлийн жилийн хөтөлбөрийн дагуу хичээл хэвийн явагдаж байгаа. Та хүүхдийнхээ сургуулийн талаараа бүрэн мэдээлэлтэй байгаа, онлайн орчинд хэрхэн ажиллах талаар чадвартай, даалгавраа хүлээн авсан ба түүнийг бие даан хийх чадвартай эсэхийг шалгаарай.
- **Сургуультайгаа харилцах.** Хэрэв таны хүүхдийн чех хэлний мэдлэг хангалтгүй, даалгавраа өөрөө хийж чадахгүй, та түүнд туслахад таны боломж бололцоо дутуу байгаа бол ангийнх нь багштай холбоо барьж түүнд мэдэгдээрэй. Ийм нөхцөл байдлаас ичих хэрэггүй. Багш нь та бүхнийг ойлгож, танд болон таны хүүхдэд туслах болно.
- **Хүүхдэдээ суралцах орчныг бүрдүүлэх.** Гэртээ сургуулийн ердийн орчинг бүрдүүлж хүүхдийг тогтмол нэг цагт босгож, мөн тогтмол нэг цагт унтуулах хэрэгтэй. Өглөөнөөс үд болох цагийг зөвхөн хичээл хийхэд зориул. Өдрийн цагаар амрах, гадаа гарах мөн гэр ахуйн ажилд туслуул.
- **Хүүхэд даалгавраа төлөвлөж, багш руугаа илгээхэд нь тусла.** Хүүхдийнхээ даалгаварт нь туслаж чадахгүй байсан ч түүнийг хийх төлөвлөгөө гаргахад нь тусла. Даалгаврыг эхний ээлжинд өдөрт бага багаар, завсарлагаатай хийж ахиулсаар улмаар дараа нь ихээр хийж амждаг болно. Хийсэн даалгаврыг багш руу зааврын дагуу илгээнэ .
- **Тусlamж хүсэхээс бүү санаа зов.** Сургуультайгаа холбоо тогтооход тусlamж хэрэгтэй байна уу? Орчуулагч, орчуулга хийх боломжтой : www.integracnicentra.cz, www.meta-ops.cz. Хэрэв таны хүүхэд гэрийн даалгавраа хийхэд тусlamж шаардлагатай бол дээрхи байгууллагуудын сайн дурын ажилтнуудтай холбоо бариарай. Холбоо барих хаягийг доорхи линкнээс авах боломжтой: <https://cizinci.npicr.cz/prehled-moznosti-distancniho-doucovani-zaku-s-odlisnym-materskym-jazykem/>
- **Хүүхдэдээ чех хэлээр ярьж ойлгох орчинг бүрдүүл.**
Та өөрөө чех хэл мэдэхгүй бол хүүхдэдээ чех хэлийг сурах орчинг аль болох боломжоороо бүрдүүл. Чех хэлийг сурахад зөвхөн багшийн өгсөн даалгаврыг хийх нь хангалттай бус юм. Чехийн зурагтаар UčíTelka эсвэл Rádio Junior зэрэг сургуулийн сурагчдад зориулсан телевизийн нэвтрүүлэг байдаг. Та <https://cizinci.npicr.cz/tlumoceni-a-preklady/#inforod> сайтаас онлайн сургалтын хичээлийг үзэж чех хэлний мэдлэгээ нэмэгдүүлэх боломжтой
Хүүхдэйтгээ хамт чех хэл сур. Та өөрийн чех хэлний мэдлэгээ сайжруулахыг хүсч байгаагаа хүүхдэдээ харуул. Чехийн кино, боловсролын хөтөлбөрүүдийг хамтдаа үзэх, аудио ном сонсох эсвэл интерактив онлайн хэл сурах хөтөлбөрт хамрагдаарай: <https://www.cestina2.cz/>, <https://www.mluvtecesky.net> эсвэл гар утасруугаа оруул [Duolingo nebo Memrise](#)
- **Хүүхдийн идэвхи чармайлтыг нь үнэлж урамшуулан шагна.** Суурь боловсролын хичээлийг өөрийн төрөлх хэлнээс өөр хэлээр суралцахад маш хэцүү. Тиймээс өөр хэл дээрхи даалгаврыг эх хэл шигээ ойлгож, хүлээн авч, тухайн даалгаврыг хийх гэж хичээн байгаа хүүхдэдээ урам зориг өгч, түүнийг чадна гэдэгт итгүүлэн бүтэлгүйтсэн үед нь туслаж дэмжээрэй.

*текстийг гадаад хэл дээр орчуулах боломжтой: <https://cizinci.npicr.cz/tlumoceni-a-preklady/#inforod>